



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/219

Номгон

Улсын төсвийн хөрөнгөөр бэлчээрийн хортон
мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6, 10.1.7, 15 дугаар зүйлийн 15.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай” 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А-143 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр олгосон 20 тн бактержуулсан будааг хангайн сумдад цацах ажлыг үр дүнтэй зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /У.Балжинням/-т даалгасугай.

2. Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулах хариуцлагатай ажилтныг томилон, ажлын хэсэг байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Бактержуулсан бэлдмэл цацах стандарт, заавар, зөвлөмжийн дагуу хүн, малын аюулгүй байдлыг ханган будаа цацах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, холбогдох дүгнэлтийг гаргаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /У.Балжинням/, сумдын Засаг дарга, ажлын хэсэгт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс /Т.Хишигбаатар/-т үүрэг болгосугай.

ДАРГА  МӨНХСАЙХАН

542310547